



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Соёл урлагийн их сургуулийн  
Бүжгийн урлагийн сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Бүжгийн урлаг

Индекс: D021507

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Пүрэвсүрэн (Ph.D), дэд проф.

Гишүүд: Б.Булган (Ph.D), дэд проф.  
Н.Мөнхзул (MBA)

2018.05.24-26

## Агуулга

Хуудас

<b>I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт .....</b>	<b>4</b>
<b>II. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт .....</b>	<b>5</b>
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт .....	5
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	7
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	9
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	13
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	17
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	20
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	23
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	25
<b>V. Оролцогчдын нэрс</b>	
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	28
II. Оюутны нэр.....	28
III. Ажил олгогч.....	28
IV. Төгсөгчид.....	29
V. Шинжээчийн багийн ажиллах хуваарь .....	30
<b>VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....</b>	<b>31</b>
<b>VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр .....</b>	
<b>VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр .....</b>	

## I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	СУИС-н Бүжгийн урлагийн сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	БҮЖГИЙН УРЛАГ DANCE ART	
<b>Индекс</b>	D021507	
<b>Шинжээчид</b>	<p><b>Ахлагчийн нэр, ажил, албан тушаал:</b> Б.Пүрэвсүрэн – ШУТИС-н БУХС-н профессор</p> <p><b>Гишүүдийн нэр, ажил, албан тушаал:</b> Б.Булган – МУБИС-н БС-н хөтөлбөрийн албаны дарга Н.Мөнхзул – Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын Соёлын өвийн хэлтсийн дарга</p>	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мядагмаа	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Зохицуулагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2018.05.24	Удирдлага болон өөрийн үнэлгээний багтай уулзах
		Сургуультай танилцах
		Багш оюутантай уулзалт хийх
	2018.05.25	Тайлантай холбогдуулан лавлагаа тодруулга авах
		Шалгалтын явцтай танилцах
		Төгсөгч, ажил олгогчтой уулзах
	2018.0526	Тайлантай бүрэн танилцсан байх
		Тайлан дүнгээ урьдчилан танилцуулах
<b>Шалгуур шаардлага /журам/</b>		

## IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Академик түвшний сургалтыг үндэсний хэмжээнд явуулдаг, мэргэшсэн
- Дэлхийн болон үндэснийхээ өв соёлд суурилсан сургалтын цогц систем, уламжлалтай
- Сургалтын орчин нөхцөл эрс шинэчлэгдсэн, багш нар нь мэргэшсэн

#### Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн асуудал, тэдгээрийн тоо, чанарт анхаарч эрдэмжүүлэх буюу эрдмийн зэрэг цолыг нэмэгдүүлэх
- Мэргэжлийн онолын хичээл, үндсэн сурах бичигт анхаарах

#### Зөвлөмж:

- Элсэгчдийг эртнээс шаталсан байдлаар элсүүлэх
- Төв болон орон нутгаас эчнээгээр элсэгчдийг хөнгөлттэй, хурдавчилсан хэлбэрээр элсүүлэх ажлыг эрчимжүүлэх

#### 1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал

- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Үзэл баримтлалын хувьд маш оновчтой. Дэлхийн сонгодог болон үндэсний онцлогыг тусгасан хичээлийн хөтөлбөртэй
- Өрнө, дорны буюу арга билэг, олон соёлт нөхцөл байдлыг бүхий л талаар хөтөлбөртөө тусгасан байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын мэдээллийн нэгдсэн системтэй болсон байна.

#### **Анхаарах асуудал:**

- Бүжгийн урлагийн сургууль өөрийн бие даасан стратеги төлөвлөгөөтэй болох
- Бүжгийн урлагийн бие хүний хөгжил төлөвшил, нийгэмд үзүүлэх гоо сайханы нөлөөллийг түлхүү анхаарах

#### **Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээ-уран бүтээлийн зөвлөлөө тогтмол ажиллагаатай болгох

### **1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал

Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр төлөвлөгөөний өөрчлөлтийг тухай бүрт нь хийж ирсэн байна
- Гадаадын оюутнууд бакалавр болон магистрантурт суралцаж төгссөн
- Сургалтын өөрийн гэсэн дэг сургууль буюу бий биелгээний өв уламжлалтай

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт тусгагдсан үндсэн хичээлүүдийн дагуу гарын авлага, ном сурах бичигтэй болох
- Цагийн багшийн тоог бууруулах

### **Зөвлөмж:**

- Төгсөгчдөө давтан болон үргэлжлүүлэн суралцуулах , гадаад дотоодын тэтгэлэгт хамруулах тоо хэмжээг нэмэгдүүлэх

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

#### **2.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага**

- Бүжгийн сургалт явуулах орчин нөхцөл сайн, анги танхимын хүрэлцээ хангамж сайн бөгөөд 2013 онтой харьцуулахад анги танхимын хэмжээ 4 дахин өссөн нь хичээлийн байрны өргөтгөл хийсэнтэй холбоотой байна.
- СУИС-н хэмжээнд хамгийн их хөрөнгө оруулалт хийж, сургалтын орчныг сайжруулсан сургууль
- Номын сан, Оюутан театр, Харзтайн дадлагын бааз зэргийг онцолж болно

### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн байрны гаднах орчны зай талбай, тохижилтыг үе шаттайгаар сайжруулах
- СУИС-н хэмжээнд оюутны дотуур байрны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх

### **Зөвлөмж:**

- СУИС-н захиргаа сургалтын орчны газрын асуудлаар хотын захиргаатай хамтран ажиллах

#### **2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Бүжгийн төрөл бүрээр хэрэглэгдэх CD, DVD болон 3000 орчим аяны нөөцтэй бөгөөд төрөлжсөн бүжгийн хувцастайгаар сургалт явуулдаг
- Бүжгийн урлагийн ном сурах бичиг болон биет бус уламжлалын дэг сургалтыг шавь сургалтаар дамжуулан авч явдаг.
- Номын сангийн баяжуулалт болон программ хангамж нь UNICULTURE системийнхээ хүрээнд шинэчлэгдсэн

### Анхаарах асуудал:

- Бүжгийн олон төрөлт сургалтыг эрхлэн явуулдаг тул олон ардын буюу монгол, сонгодог бүжгийн сургалтын материалуудыг текст, аудио видео зэрэг бүх төрлөөр өргөтгөн бүрдүүлэх,
- Үндэсний мэргэжлийн урлагийн театр, чуулгуудад дэглэгдэн тавигдсан бүжгийн урлагийн урын сангаас сургалтандаа хэрэглэх, баяжуулах шаардлагатай

### Зөвлөмж:

- Бүжгийн урлагийн талбарт мэргэшин ажиллаж буй хэнийг ч хүний нөөцийн боломж гэдэг утгаар нь дайчлан ашиглаж, үзүүлэх тоглолт сургалтыг явуулж, харилцан туршлага солилцдог байх

### 2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

### Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Нээлттэй цахим эх үүсвэрийг түлхүү ашигладаг
- Бий биелгээний үндсэн сурах бичиг гарын авлагаа шинэчлэн хэвлүүлсэн
- Бүжгийн урлаг сэтгүүлийг шинээр эрхлэн гаргаж эхэлсэн

### Анхаарах асуудал:

- Цаашид сургалтын орлогоо нэмэгдүүлэхийн хирээр түүнд зарцуулах мөнгөн дүнг нэмэгдүүлэх
- Lib 4U KOXA программаа эрчимтэй хөгжүүлэх

### Зөвлөмж:

- Багш нарынхаа ном сурах бичиг гарын авлага хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх ажлыг улам дэмжин урамшуулах

## **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- UNICULTURE удирдлагын мэдээллийн систем 2013 оноос Бүжгийн урлагийн сургуульд нэвтэрсэн. Энэ нь багш, оюутан, удирдлага, ажилтнууд нэг цонхоор мэдээлэл солилцох, харилцах урсгал бий болж, сургалтын үйл ажиллагааг цахимаар оновчтой удирдан зохион байгуулах давуу тал бий болсон.
- СУИС-ийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний зорилтын хүрээнд "Багшийн хөгжил хөтөлбөр"-ийг 2011 онд батлуулж, хөтөлбөрийн хүрээнд судлаач багш нарыг бэлтгэх, тэдний үйл ажиллагааг идэвхижүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийсэн байна. Үүний үр дүнд Докторын зэрэг хамгаалсан, дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлсэн багш нарын тоо жил ирэх тутам өссөн байдал 2013 оноос 2 жил тутам хийгдсэн Бүжгийн урлагийн хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаанаас харагдаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ном сурах бичиг, гарын авлага, материалыг үе шаттайгаар нэмэгдүүлэх шаардлагатай болох нь Хүснэгт 28-с харагдаж байна.



**Зөвлөмж:**

- МУ-ын Дээд боловсролын тухай хууль, Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журам, СУИС-ийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө г.м бусад баримт бичгийг үндэслэн Бүжгийн урлагийн сургууль жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан СУИС-ийн захиргааны зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлдэг байна. Цаашид Бүжгийн урлагийн сургууль урт, дунд хугацааны төлөвлөлтийг дээрх баримт бичигтэй уялдуулан боловсруулж сургуулийн хөгжлийн ирээдүйг төсөөлөн ажиллах нь зүйтэй.

**3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- БСШУСЯ-ны захиалгаар СУИС-аас Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн судалгааг 2017 онд хийсэн байна. Судалгаагаар бүжгийн урлагийн хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгаа бүрэн хийгдсэн байна. Бүжгийн урлагийн хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулах боломж бүрдсэн давуу талтай.

- Хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагааг шууд байдлаар болон цахим идэвхижүүлэлтийн цогц аргыг хэрэглэж зохион байгуулсны үр дүнд Бүжгийн урлагийн хөтөлбөрт элсэхийг сонирхогчдын тоо нэмэгдэж, тэдний дунд өрсөлдөөн бий болсон байна.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн маркетингийг үзэгчдэд биш ирээдүйн бүжгийн урлаг хөтөлбөрөөр суралцагчдад чиглэсэн байдлаар явуулах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээл, маркетингийн орчин байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул Бүжгийн урлаг хөтөлбөрийн маркетингийн хөтөлбөр боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих систем тогтолцоог бий болгох шаардлагатай.

**3.3 Төгсөлтийн дараах бодлого**

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийг мөшгих судалгааг тогтмолжуулж, сургалтын үйл ажиллагаанд ажил олгогчын санал дүгнэлтийг тусгаж байгаа нь төгсөгчдийн ажлын байрны эрэлт хэрэгцээг тодорхойлох, тэднийг давтан сургах, үргэлжлүүлэн суралцуулах бодлого тодорхойлоход дэмжлэг болж байгаа нь өөрийн үнэлгээний тайлан болон нотлох баримтаас харагдаж байна.
- Мөн үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ ахисан түвшин /магистр/-д хүрсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Диплом олон улсад хүлээн зөвшөөрөгдөхийн нэг үндэс бол ойлгомжтой байдал бөгөөд мэргэжил, мэргэшлийн нэр, дипломын дүнгийн хавсралтыг англиар хэвлэн гаргадаг болгох
- Төгсөгчдийг давтан сургах хөтөлбөр, төлөвлөгөөг тусгайлан боловсруулж, батлан хэрэгжүүлэх шаардлагатай.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн карьерын түвшинг зөвхөн ахисан болон түвшний сургалтад хамрагдснаар тооцохоос гадна, шинэ бүтээл, оновчтой санаа, онол практикийн нээлт, судалгаа, шинжилгээ, бүтээл туурвиж олон нийтэд хэвлэн нийтэлсэн зэргийг харгалзан тооцож байх шаардлагатай.

### **3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа**

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- СУИС-ийн гадаад харилцаа өргөжихийн хирээр Бүжгийн сургуулийн гадаад харилцаа тэлж, олон улсын хурал, семинар, солилцооны тоглолт, хөтөлбөрт оролцогчдын тоо нэмэгдсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Гадаад хамтын ажиллагааны тогтвортой хөгжлийг хангахын тулд нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллах, шинэ тутам санаачлан хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны хэлбэрүүдийг тогтмолжуулах

**Зөвлөмж:**

- Олон улсын төсөл хөтөлбөрөөр гадаадын мэрэгжилтэн багшийг урьж ажилуулах.

**3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Бүжгийн сургуулиас санаачлан нийгэм рүү чиглэн зохион байгуулдаг төрөл бүрийн төлөвлөгөөт ажлууд хийгдэж, тогтмолжсон байна. ‘Хотын гудамж-миний нутаг’, ‘Бид сайн сайханд дагуулна’ зэрэг олон нийтэд зориулсан үйл ажиллагаа Бүжгийн сургуулийг түшиглэн зохион байгуулагдаж, Бүжгийн сургууль болон бүжгийн урлагийн хөтөлбөрийг сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна.
- Үндэсний баяр наадам болон төрийн албан ёсны урлагийн нэгдсэн арга хэмжээнд багш оюутнууд тогтмол оролцдог байна.

**Анхаарах асуудал:**

- Багш оюутны нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хөдөлмөр цаг зарцуулалтыг илүү бодитой тодорхой үнэлдэг болгох

**Зөвлөмж:**

- Төрийн хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтын ажиллагааны оновчтой үр ашигтай хэлбэр бүрийг туршин хэрэгжүүлэх
- Соёлын үйлчилгээний хүрээнд нийтийн бүжгийн төрөл хэлбэрийг түгээн дэлгэрүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

**3.6 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Бүжгийн урлагийн сургууль бие даасан санхүүгийн эх үүсвэртэй. Бүжгийн урлагийн хөтөлбөр нь сургалтын төлбөр, гадаад дотоодын төсөл хөтөлбөр, сургалт, уран бүтээлийн тоглолт, сургалтын урын санг баяжуулах төслүүдийн орлого, богино хэмжээний сургалтын орлого зэргээр олон төрлийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж, орлого бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсан байна.
- Сургалтын орчин, компьютер тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж сайжирч, энэ нь үйл ажиллагаагаа өргөтгөх, төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах улмаар хөрөнгө оруулалтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

Одоо байгаа нөөц, хэтийн зорилгоо тодорхойлон шаардлагатай нөөцийг бүрдүүлэх талаар баримт бичиг боловсруулан түүнийгээ санхүүгийн үйл ажиллагаагаа төлөвлөх, мөн хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлд зориулан тусгайлан төсөв батлуулах, жил бүрийн батлдагдсан төсвийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж хөтөлбөрийн хөгжлийн хэтийн төлөвийг судалгаанд үндэслэн илүү бодитой төлөвлөж, хөтөлбөрийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай байгаа нь тухайн тайланд тусгагдсан байна. Иймд хөтөлбөрийн орлого зарлагын төлөвлөлтийн механизмыг сайжруулж, хөтөлбөрийн тогтвортой үйл ажиллагааг хангах эх үүсвэрийг бүрдүүлэх зорилго бүхий хэтийн төлөвлөгөө боловсруулан холбогдох газраар батлуулан ажиллах.

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **4.1 Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Бүжгийн урлагийн хөтөлбөрийн элсэгчдээ хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцүүлэн хот, хөдөөгийн мэргэжлийн сургалттай сургуулиуд, театр чуулгуудтай хамтран зохион байгуулдгаараа онцлог байна. Энэ нь эргээд төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь, хэмжээ өндөр байхад нөлөөлсөн хүчин зүйлүүдийн нэг болсон байна.
- Шинээр элсэн орсон суралцагчид удирдлагын мэдээллийн UNICULTURE системийн оюутан программыг ашиглан сургалтын үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллээ бүрэн авдаг байна. Мөн сургалтын албанаас суралцах хүсэл тэмүүллийг төрүүлэх зорилгоор мэргэжил сурталчлах өдөрлөг, багш нартай танилцах уулзалтыг зохион байгуулдаг байна.

#### **Анхаарах асуудал:**

- Элсэгчдийн ерөнхий шалгалт болон мэргэжлийн шалгалтын дунджаар жил жилээр хэлбэлзэлтэй байгааг анхаарах. Хүснэгт 58 Өөрөөр хэлбэл авьяастай төдийгүй ерөнхий мэдлэг сайтай элсэгчдийг элсүүлэх

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг сурталчлах ажлыг идэвхжүүлж, хөтөлбөрт элсэгч, өргөдөл гаргагчдын тоог нэмэгдүүлэх, элсэлтийн шалгалтын шалгуурыг хөтөлбөрийг шинэчлэлийн хүрээнд боловсронгуй болгох

#### **4.2 Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үрдүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал

- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Зөвлөх үйлчилгээний төлөвлөгөө, график гарган жил бүр ажиллаж, үр дүнг тооцох зорилгоор судалгаа авсан байна. Судалгаагаар зөвлөх үйлчилгээ, сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ихэвчлэн /47,3%/ мэргэжлийн багшаас авдаг гэжээ. Мөн суралцагчдын төлөөлөлтэй уулзах үеэр оюутнууд мэргэжлийн багшийг гэр бүлийн гишүүнтэйгээ зүйрлэн ярьж байсан. Энэ нь багш Мэргэжлийн багш нар суралцагчдаа мэргэжлийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ зөвлөх үйлчилгээ, мэдээлэл солилцооны урсгал багш оюутны хооронд идэвхитэй явагддагийг харуулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Зөвлөх үйлчилгээний төлөвлөгөө, график гарган жил бүр ажиллаж, үр дүнг тооцох зорилгоор судалгаа авсан байна. Сургуулийн хэмжээнд болж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хаанаас олж авдаг гэсэн асуултад сургалтын алба хамгийн бага буюу 14,7 хувийг эзэлж байна. Иймээс сургалтын албанаас оюутан руу чиглэсэн үйл ажиллагааг идэвхижүүлэх шаардлагатай.
- Номын сангийн орчин нөхцөл шаардагдсан хэдий ч, номын татгалзал өндөр, номын сангийн үйлчилгээ түргэн шуурхай бус байгаа асуудлыг судлан үзэж, шаардлагатай арга хэмжээ авах

#### **4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг**

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сүүлийн жилүүдэд Оюутны үйлчилгээний төсөв жил бүр өсөж гурав дахин өссөн байна

#### **Анхаарах асуудал:**

- Бүжгийн урлагийн сургуулийн Оюутны зөвлөлийг бие даасан өрөөтэй болгох

**Зөвлөмж:**

- Оюутны байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, түүнээс санаачилсан оюутан руу болон нийгэм рүү чиглэсэн ажлыг дэмжих, арга зүйгээр хангахад чиглэн сургалтын албанаас тодорхой ажлыг үе шаттайгаар төлөвлөх

#### **4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо**

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Үндэсний тэтгэлэгт болон сургуулийн урамшууллын тогтолцоог жигд хэрэглэж байна

**Анхаарах асуудал:**

- Суралцагчдын авьяас чадварыг мэргэжил төдийгүй бусад олон талт үзүүлэлтээр тэтгэн урамшуулах, алдаршуулах үйл хэргийг өргөтгөх
- Гадаад дотоодын сан, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах үйл хэргийг улам бүр нэмэгдүүлэх

**Зөвлөмж:**

- Суралцагчдад олгох тэтгэлгийн шалгуур болсон голч оноог хэт өндөрсгөхгүй байх

#### **4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Их сургууль нь шилжилт хөдөлгөөний дүрэм журамтай

### **Анхаарах асуудал:**

- Бүжгийн урлагаас багш, урлагийн боловсрол хөтөлбөр лүү түлхүү шилжин суралцаж буй байдалд дүн шинжилгээ хийх

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого
- Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна. сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш сонгон шалгаруулах дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлснээр БУС-ийн хүний нөөц, багшлах бүрэлдэхүүний бүтэц, чанарт эерэг нөлөө үзүүлсэн.

- Бүжиг судлалын чиглэлээр анхны доктор БУС-иас төрсөн, докторантурт суралцах багшийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

- “Ардын урлаг, бүжиг судлал” профессорын баг бий болж, судалгаа, эрдэм шинжилгээний төсөл боловсруулж хэрэгжүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, ном, бүтээл туурвих, оюутны бичвэрийн ажлыг удирдах, чиглүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлж, чанарын ахиц гарч буй.

#### **Анхаарах асуудал:**

- Докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийг нэмэгдүүлэхийн тулд гадаадын их, дээд сургуулиудтай тодорхой чиглэлээр хамтран ажиллах, хөтөлбөр хэрэгжүүлэх



- Сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлагатай хүмүүсээс цагийн багш нараа бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэх

**Зөвлөмж:**

- Гадаадаас багш урих, багшаа гадаадад сургах
- Хүний нөөцийн менежменттэй болох

**5.2 Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар бие биеэсээ суралцах, туршлага солилцох, залуу багш нарыг дагалдуулан сургах талаар туршлага хуримтлуулсан.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж буй. Тайваны Тайпей Урлагийн Их Сургууль, Дорнод Сибирийн Соёл Урлагийн Академи, Солонгосын К-АРТ Соёл Урлагийн Сургууль, АНУ-ын Колумбын коллеж, БНХАУ-ын Өвөрмонголын Урлагийн Их сургууль, Тунляо дээд сургуулийн багш нартай хамтран ажиллаж байна.
- “Багшийн хөгжил” хөтөлбөрийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа.

**Анхаарах асуудал:**

- Багш нарыг дотоод, гадаадын сургалт семинарт тогтмол хамруулах
- Таван жил тутамд хийдэг дотоодын магадлан итгэмжлэлийн чанарт анхаарах, хэрэгцээндээ тулгуурлан, цаашдын ажлын төлөвлөлтийг хамтран хэлэлцэж боловсруулах, хэрэгжүүлэх

**Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийн судалгааг тогтмол хийх, энэ талаарх мэдээллийн санг чанартай бүрдүүлэх
- БУС-ийн онцлогийг тусгасан хүний нөөцийн цогц бодлого, хөгжлийг дэмжих ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилт буюу явц, үр дүнг тогтмол хэлэлцдэг, тайлагнадаг болох

**5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Профессорын багийн судалгааны үр дүнд тулгуурлан, урлагийн бүтээл туурвиж, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж, сурах бичиг, гарын авлага, CD зэргийг хэвлэн, сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж байна.
- Бүжгийн хөгжмийн судалгаа, сургалтыг хослуулан, “багш-оюутан-хөгжим” гурвын нийцэлд анхаарч, тодорхой үр дүнд хүрээд байна.
- Сүүлийн жилүүдэд 10 гаруй төсөл, хөтөлбөрийг олон улсын байгууллага, гадаадын их, дээд сургуулиудтай хамтран хэрэгжүүлж, монгол туургатны язгуур бүжгийн хөгжил, өнөөгийн байдал, цаашдын шинэчлэлд өөрийн хувь нэмрийг оруулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Суурь судалгааг цаашид өргөжүүлэх, төсөв санхүүжилтийг олон эх үүсвэрээс эрж хайх
- Гадаад, дотоодын их, дээд сургууль, тэнхим хоорондын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Багш нарт эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа чанартай хийж, чансаатай илтгэл, өгүүлэл бичихэд дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Судалгаанд суурилж, инновацийг бий болгох, бүжгийн урлагийн инноваци бүтээх, патенттай болох

#### **5.4 Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчилал, эрэмбэлэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар 3 жил тутам өөрийн үнэлгээний тайлан бичиж, түүнд тулгуурлан, багшийн үйл ажиллагааг хянаж үнэлэх, урамшуулах, сайжруулах ажил тогтмол хийгддэг.

- БУС-ийн Сургалтын албанаас багшийг оюутнаар, багшийг багшаар үнэлүүлэх ажлыг санал асуулга, заавар зөвлөмжийн дагуу тогтмол зохион байгуулдаг. Үүний үр дүнд багшийн албан тушаалын зэрэглэлийг ахиулах, бууруулах, багш нарт тулгарч буй асуудал, бэрхшээлийг олж илрүүлэх, шийдвэрлэх талаар зохих туршлага хуримтлуулсан.

- Хичээлийн жилийн эхэнд сургуулийн захирал, сургалтын албаны дарга, мэргэжилтэн, багш нар оюутнуудтай уулзалт хийж, тухайн хичээлийн зорилго, зорилтоо танилцуулж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, улмаар жилийн эцэст үнэлүүлж хэвшсэн.

### **Анхаарах асуудал:**

- Багш нарын ачааллыг тэнцвэржүүлэх, үйл ажиллагаа, үр дүнгийн чанарт анхаарах

- Багш нарыг гадаадад урт, богино хугацааны сургалтад хамруулах

- Аттестатчиллын асуулгыг урлагийн нарийн мэргэжлийн багш нарт тохируулан өөрчлөх, асуулга, шалгуур үзүүлэлт зэргийг хамтарч боловсруулан хэлэлцэх

### **Зөвлөмж:**

- Багш нар оюутантай тулж ажиллах, уран бүтээл туурвихад их цаг зарцуулж, эрдмийн ажилд бага анхаарч байгаад дотоод зохицуулалт хийж дэмжих

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд санхүүжилт, дэмжлэгийг өсгөх, судалгаанд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гаргах

### **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал

- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2014.07.4-ний хурлаар хэлэлцэн баталсан “Бүжгийн урлаг” сургалтын төлөвлөгөөний дагуу ерөнхий суурь 37 кр/28,4%, мэргэжлийн суурь 36 кр/27,6%, мэргэжлийн 48 кр/37%, дадлага 4 кр/3%, дипломын ажил, төсөл 5 кр/4%, нийт 130 кр хичээл судална. Сургалтын агуулга нь онол, дадлагын зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, суралцагч сонгох боломжтой.
- Төгсөгчид, ажил олгогчдоос авсан судалгаанд үндэслэн, Хүний бие судлал, Хөдөлгөөний анализ, Урлагийн сэтгэл судлал зэрэг шинэ агуулга бүхий сонгон суралцах хичээлүүдийг нэмж оруулсан.
- Онол, дадлагын хичээлийг зохистой харьцааг хангасан бөгөөд хичээл тус бүр лекц /24,19%, семинар /18,54%, дадлага, практик /57,25%/-ийг оновчтой хослуулсан.

#### **Анхаарах зүйл:**

- Агуулгын матриц гаргаж, тохирцын шинжилгээ хийх
- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг тандан судалж, агуулгыг шинэчилдэг байх

#### **Зөвлөмж:**

- Сургалтыг эрдэм шинжилгээ, судалгаатай холбох, судалгааны үр дүнг сургалтад нэвтрүүлэх, мэдлэгийг инноваци болгосон уран бүтээл туурвих, өөрөөр хэлбэл, “сургалт-судалгаа-уран бүтээл” гэсэн шатлалын доторх судалгаа шинжилгээнд ач холбогдол өгч, бүжгийн урлаг судлалын төв болох
- Хичээл хоорондын уялдааг хангахын тулд багш нар хичээлийн агуулгаа хамтран боловсруулах, сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг хамтран бүтээх

### **6.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал

- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- Нэг талаас, багшийн чиглүүлэг мэдээлэл өгөх, нөгөө талаас, оюутны судлах, биечлэн хийж гүйцэтгэх үйл ажиллагааг нэгтгэсэн сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй байна.
- Сургалтын дэвшилтэт арга технологи болох асуудалд суурилсан сургалт, интерактив лекц, биеэр хийж гүйцэтгэх сургалтыг амжилттай хэрэгжүүлдэг.
- Нээлттэй хичээл, мастер класс зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, гадаад багш, уран бүтээлч нартай хамтарч сургалт зохион байгуулдаг.

#### **Анхаарах зүйл:**

- Хичээлийн хөтөлбөр бүрээр арга зүйд дүн шинжилгээ хийх, арга зүйн матриц гаргах
- Багш нарын арга зүйн хөгжлийг дэмжих сургалт зохион байгуулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Сургалтын арга зүй болон сургалтад хэрэглэж буй мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи программ хангамж техник хэрэгслийг сайжруулах
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь суралцагчдын мэдлэг чадвар, хөгжлийн түвшинд хэр нийцэж байгаа болон багш нар сургалтад мэдээлэл харилцааны технологи, программ хангамжийг хэр зэрэг бүтээлчээр ашиглаж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийх

### **6.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- Мэргэжлийн хичээл бүрээр улиралд 1 удаа академик шалгалт авч, хэлэлцүүлэг хийдэг систем тогтсон.
- Үнэлгээтэй холбоотой оюутанд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх зорилгоор Сургалтын албанаас мэдээлэл цуглуулдаг.
- Явцын үнэлгээ 20 оноо тавьдаг байсныг өөрчилж, хичээлийн ирц, идэвх, бие даалт, явцын сорил I,II, шалгалт болгон задалж, оюутны 70, шалгалтын 30 оноогоор үнэлэх аргачлалыг хэрэглэдэг.

#### **Анхаарах зүйл:**

- Нэгдмэл бие даалт, нэгдмэл үнэлгээг туршин хэрэгжүүлэх
- Оюутнуудад үнэлгээний арга, аргачлалын талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэх

#### **Зөвлөмж:**

- Сургалтын хөтөлбөрийн үр дүнг бодитой үнэлэх
- Бичвэрийн ажилд тоон болон чанарын судалгаа хийх, бичвэрийн ажлын сэдвийн хэлэлцүүлэг, сэдвийн судалгаа хийх, дараагийн шатны судалгаа болгож гүнзгийрүүлэх

### **Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө**

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

#### **7.1. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Ажил эрхлэлтийн судалгааг СУИС-н хэмжээнд нэгдсэн байдлаар явуулсан байх бөгөөд бүжгийн урлагийн мэргэжлээрээ ажил эрхлэлт дунджаар 84,6 хувьтай байна.
- Ажил олгогч болон төгсөгчдийн төлөөллийн үзэж буйгаар бол төгсөгч нар бүжгийн олон төрлөөр суралцан төгсдөг нь нэг талаар давуутай хэмээн үзэж байна
- Ажил олгогчдын зүгээс төгсөгч нарт ихэнхидээ сэтгэл ханамжтай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Судалгаанаас үзэхэд төгсөгчдийн бичгийн болон гадаад хэлний чадвар дээр анхаарах хэрэгцээ шаардлага байна

- Оюутнуудын сургалтын тэтгэлэгт хамрагдах боломж мэдээлэлд анхаарах
- Эчнээ сургалтын кредит дүйцүүлэлт болон хугацаанд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Сургалтын цар хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх, ахисан түвшний сургалтанд анхаарах

#### **7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:**

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Д.Нанжид, Ц.Сэвжид, Г.Долгорсүрэн, Б.Алтанцэцэг нарын нэрэмжит үндэсний хэмжээний мэргэжлийн уралдаан тэмцээнд болон олон улсын уралдаан тэмцээнд тогтмол оролцож амжилт гаргадаг
  - Мэргэжлийн урлагийн байгууллагад багш, бүжиг дэглээчээр ажиллаж байна
  - Гадаад оюутнуудыг олноор сургаж төгсгөсөн туршлагатай

#### **Анхаарах асуудал:**

- Цаашид гадаадтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх нь багш болон төгсөгчдийн эрдмийн болон гадаад хэлний чадвард эерэг нөлөө үзүүлэх боломжтой
  - Багш болон оюутан солилцоог идэвхижүүлэх
  - Бүх талын хамтарсан уран бүтээл туурьвих ажлыг эрчимжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах

#### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжил
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- БНХАУ-н 17 оюутанг сургасан туршлагатай
- Гадаадад болон гадаадын мэргэжилтэн багш нартай хамтран бүжгийн урлагийг сурталчлах ажлыг удаа дараа зохион байгуулж байсан
- Багш оюутан нараас олон улсын уралдаан тэмцээнд оролцож тэргүүн болон эхний байруудыг эзлэж байсан

### Анхаарах асуудал:

- Төгсөгчдөө гадаадад үргэлжлүүлэн суралцуулах тал дээр анхаарах

### Зөвлөмж:

- Суралцагчдын сонирхол, хүслийг харгалзан хос мэргэжлээр суралцуулах
- Багш оюутны гаргасан урлагийн амжилтыг зэрэглэлээс хамааруулж урамшуулах кредитийн тогтолцоотой болох

#### 7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

### Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- “Өв соёл” Үндэсний Олон нийтийн телевизийн нэвтрүүлэгт оролцдог
- msuac.edu.mn Вебсайтаа тогтмол ажилуулж, “Бүжгийн урлаг” мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргасан
- Ахмад багш нараа алдаршуулах ажлыг сургуулийн захиргаа маш амжилттай хэрэгжүүлсэн

### Анхаарах асуудал:

- Их сургуулийнхаа удирдлага, мэдээллийн системийг амжилттай хэрэгжүүлж хөгжүүлэх үүднээс бүжгийн сургууль өөрийн мэдээлэл харилцааны технологийн ажилтантай болох

## 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.



## 8.1 Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажууллыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн дотоод чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг хөгжин төлөвших, тогтвортой ажиллах хувилбарыг эрж хайж, зөв төлөвшүүлэх бодлого барьж ажиллаж буй.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, явцын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, санхүүгийн байдлын шинжилгээ зэргийг жил бүр, улирал бүр, хуваарийн дагуу тогтмол хийхээр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн.
- “Бүжгийн урлаг” хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн ур чадварын үнэлгээ, мэдлэг, чадварын өөрийн үнэлгээ, мэргэжлээрээ ажиллахад шаардлагатай ерөнхий ур чадварын харьцуулалт, БУС-ийн үйл ажиллагаанд анхаарах асуудал зэрэг хөтөлбөрийн хөгжилд хувь нэмэр оруулах судалгааг системтэй авсан.

#### Анхаарах асуудал:

- Шинээр оруулсан хичээл, кредит нэмэгдэж, хасагдсан хичээл, нэр нэршил өөрчлөгдсөн хичээл, агуулга шинэчлэгдсэн хичээл, судлах улирал өөрчлөгдсөн хичээл зэрэг хөтөлбөрт орсон өөрчлөлтийн үр нөлөөг тогтмол хянах
- Хөтөлбөр бүрийн гарц, үр дүнгийн тайлан гаргах, түүнд тулгуурлан үнэлэлт, дүгнэлт өгөх, сайжруулах арга замаа тодорхойлох, тогтмол хэлэлцүүлэг хийх

#### Зөвлөмж:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг оролцогч болон сонирхогч талуудаас тандаж, нийцлийн судалгаа гаргах
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоог яаж хийв, цаашид яаж өөрчлөх вэ? Ямар хүнийг бэлтгэв, бэлтгэх явцад ямар асуудал гарав, цаашид яаж сайжруулах вэ? гэх зэргээр сургууль, тэнхимийн хэмжээнд нэгдсэн хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулах

### 8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## ДҮГНЭЛТ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
3	Хөтөлбийн удирдлага, зохион байгуулалт	2			
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
5	Багшийн үйл ажиллагаа	2			
6	Сургалтын үйл ажиллагаа	2			
7	Хөтөлбөрийн үр дүн, үр	2			
8	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
<b>Дүгнэлт</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

### ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн “Бүжгийн урлаг” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Б.Пүрэвсүрэн/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг ...../Б.Булган/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Н.Мөнхзул

## V. Оролцогчдын нэрс

### I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ж.Эрдэнэхорлоо	ЭНБД	Доктор	23	Монгол бүжиг Монгол бүжиг заах арга зүй Олон үндэстэн
2	Д.Алтантуяа	Тэнхмийн эрхлэгч	Магистр	35	Сонгодог бүжиг, Сонгодог бүжгийн заах арга зүй
3	Г.Барбаатар	Ахлах багш	Магистр	13	Монгол, олон үндэстэн
4	С.Гэрэлтуяа	Тэнхмийн эрхлэгч	Магистр	23	Орчин үеийн бүжиг, Сонгодог
5	Л.Мөнхтулга	Багш	Магистр	15	Бүжгийн концертмейстер

### II. Оюутны нэр

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Б.Билгүүн 2,07, Б.Оюун-Ундрах 2,4	БН-2	Мэргэжил болон, курс, голч
2	Ц.Амгаланбаяр 3,22, А.Намуун 2,57	БУ-3	Мэргэжил болон, курс, голч
3	Б.Сод-Эрдэнэ 1,65, А.Мөнхнаран 2,57	БУ-3	Мэргэжил болон, курс, голч

### III. Ажил олгогч

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Д.Баярбаатар	Үндэсний урлагийн их театр	Ерөнхий бүжиг дэглээч
2.	Л.Баттөр	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын	Уран сайхны удирдаач
3.	Т.Отгонсүрэн	Үндэсний дуу бүжгийн “Түмэн эх” чуулга	Дарга

### IV. Төгсөгчид

<b>№</b>	<b>Овог нэрс</b>	<b>Төгссөн он</b>	<b>Байгууллага</b>	<b>Албан тушаал</b>
1.	Б.Байгальмаа	2014	Үндэсний дуу бүжгийн “Түмэн эх” чуулга	Бүжигчин
2.	Б.Эрдэнэбаяр	2017	Үндэсний дуу бүжгийн “Түмэн эх” чуулга	Бүжигчин
3.	Ё.Дамчаабадгар	2017	Цагдаагийн “Сүлд” чуулга	Бүжигчин
4.	А.Нармандал	2017	СУИС	Магистрант

**Соёл урлагийн их сургуулийн Бүжгийн урлагийн сургуулийн “Багш, урлагийн боловсрол”, “Бүжгийн урлаг” сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь**

**2018 оны 5 дугаар сарын 24, 25, 26**

<b>Хугацаа</b>	<b>Үйл ажиллагаа</b>	<b>Өрөө</b>	<b>Хариуцах эзэн</b>
<b>2018.05.24 Мягмар гараг</b>			
09:00-09:10	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна	313 тоот	Зохицуулагч
09:10-09:15	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	313 тоот	Шинжээчийн багийн ахлагч
09:15-09:20	Сургуулийн захирал үг хэлнэ	313 тоот	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
09:20-09:40	Удирдлага болон ӨҮ-ний багтай уулзах: - Удирдлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	313 тоот	Шинжээчийн багийн ахлагч
09:40-10:40	Сургуультай танилцах аялал Номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана.	Хичээлийн 2-р байр	Шинжээчид
10:40-12:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана	303 тоот	Шинжээчид
12:00-13:00	Шинжээчид номын сан болон оюутан театр, үйлчилгээний хэсэгтэй танилцана.	Хичээлийн 1, 3-р байр	Шинжээчид
13:00-14:00	Цайны завсарлага		
14:00-15:00	Оюутнуудтай хийх уулзалт	313 тоот	Шинжээчид
15:00-16:00	Багш нартай хийх уулзалт	313 тоот	Шинжээчид
16:00-18:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	303 тоот	Шинжээчид
<b>2018.05.25 Баасан гараг</b>			
9:00-10:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	303 тоот	Шинжээчид
10:30-12:30	Батлах шалгалтын явцтай танилцах	I, II заал	Шинжээчид
12:30-13:30	Цайны завсарлага		
13:30-14:30	Төгсөгчидтэй хийх уулзалт	313 тоот	Шинжээчид
14:30-15:30	Ажил олгогчидтой хийх уулзалт	313 тоот	
15:30-18:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	303 тоот	
<b>2018.5.26 Бямба гараг</b>			

<b>10:00-11:00</b>	<b>Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах</b>	<b>303 тоот</b>	<b>Шинжээчид</b>
<b>11:00-12:00</b>	<b>Гудамжны баярын үйл ажиллагаатай танилцах</b>		
<b>12:00-13:00</b>	<b>Цайны завсарлага</b>		
<b>13:00-15:00</b>	<b>Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/</b>	<b>303 тоот</b>	
<b>15:00-16:00</b>	<b>Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.</b>	<b>303 тоот</b>	

## VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



### СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ БҮЖГИЙН УРЛАГИЙН СУРГУУЛЬ

14181 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
11 дүгээр хороо, СУИС-ийн хичээлийн II байр,  
Утас: 7000 1995, И-мэйл: suisbus@gmail.com

2018.10.24 № 91  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

“Бүжгийн урлаг” хөтөлбөрийн шалгуур тус бүрээр гаргасан үнэлэлт, цаашид анхаарах асуудал, зөвлөмж бүхий шинжээчийн тайлантай тус хөтөлбөрийн өөрийн үнэлгээний баг танилцаж тайланг хүлээн зөвшөөрч байгааг уламжилж байна.

ЗАХИРАЛ  Ч.БАТ-ЭРДЭНЭ